

НИЙСЛЭЛИЙН БОЛОН БҮСИЙН МЭДЭЭЛЭЛ ЗҮЙН ОЛИМПИАДЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

2026.02.03

1. Ерөнхий зүйл

- 1.1. Нийслэлийн болон бүсийн Мэдээлэл зүйн олимпиадын зорилго нь нийслэлийн болон хөдөө орон нутгийн багш, сурагчдын тооцоолох сэтгэлгээний илрэл болох кодчиллын мэдлэг, ур чадварын хөгжлийг дэмжих, бүтээлч сэтгэлгээг нээн илрүүлэх, улмаар нийт сурагчдын шинжлэх ухааны мэдлэг, чадвар хөгжилд хувь нэмэр оруулахад оршино.

2. Олимпиадын хамрах хүрээ

- 2.1. Нийслэл болон бүсийн мэдээлэл зүйн олимпиадыг дунд (10 болон түүнээс доош анги), ахлах (11 ба 12 дугаар анги), багш гэсэн гурван ангиллаар зохион байгуулна.
- 2.2. Бүс бүрээс эхний 2 байр эзэлсэн багш, сурагчдад Улсын олимпиадад оролцох эрх олгоно. Аймгийн олимпиадаас эрх авсан оролцогчид бүсийн эрх хамаарахгүй.
- 2.3. Нийслэлээс оролцох багш, сурагчийн тоонд олимпиадын нийтлэг журамд заасан тоог баримтална.

3. Зохион байгуулалт, хугацаа

Бүсүүдийг дараах байдлаар хуваана. Үүнд:

- 3.1. Баруун бүс: Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Ховд, **УВС**
- 3.2. Хангайн бүс: Архангай, Баянхонгор, **ӨВӨРХАНГАЙ**
- 3.3. Хойд бүс: Булган, Хөвсгөл, **ОРХОН**
- 3.4. Төвийн бүс: Төв, Сэлэнгэ, **ДАРХАН-УУЛ**
- 3.5. Говийн бүс: Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь, **ДОРНОГОВЬ**
- 3.6. Зүүн бүс: Хэнтий, Дорнод, **СҮХБААТАР**

Бүсийн олимпиадыг тухайн бүсийн аймгуудын саналд үндэслэн дараах 2 хэлбэрээр олимпиадыг зохион байгуулна. Үүнд:

- 3.7. Onsite – бусад аймгийн оролцогчид бүсийн олимпиадыг зохион байгуулж буй аймагт очиж оролцох хэлбэр. Бүсийн олимпиадыг зохион байгуулах үндсэн хэлбэр нь онсайт байна.
- 3.8. Online – зарим аймгийн оролцогчид бүсийн олимпиадыг зохион байгуулж буй аймагт очихгүйгээр зайнаас оролцох хэлбэр. Энэ хэлбэрийг хөл хорио тогтоосон, цас зудын нөхцөл хүндэрсэн зэрэг онцгой байдал үүссэнээс унаа машинаар зорчих боломжгүй болсон үед зарим аймаг хүсэлт гаргасан тохиолдолд хэрэгжүүлж болно. Бүсийн олимпиадад онлайнаар оролцох тохиолдолд нийт оролцогчид аймгийн төв дээрээсээ нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцоно. Ингэхдээ нэг танхимд цуглан ашиг сонирхлын зөрчилгүй тусгай хянагч багш нарын хяналтын дор оролцох ба олимпиадын нийт хугацаанд оролцогч бүрийн дэлгэцийг видео хэлбэрээр бичиж, нийт суралцагчийн хуулаагүй, хоорондоо харилцаа үүсгээгүй, өөр цахим төхөөрөмж, нэмэлт материал ашиглаагүй болохыг баталгаажуулах зорилгоор хэд хэдэн (лабораторийн онцлогоос шалтгаалж 2 болон түүнээс дээш) хяналтыг камераар оролцогчдын нүүрийг харуулалгүйгээр тасралтгүй бичих боломжтой орчин нөхцөлийг бүрдүүлсэн компьютерын лабораторид явуулна. Энэ нөхцөлийг биелүүлээгүй эсвэл бие биеэсээ хуулсан, интернэт ашигласан, хоорондоо харилцаа үүсгэсэн, зөөврийн төхөөрөмж, гар утас болон ухаалаг төхөөрөмж ашигласан зэрэг зөрчлийн аль нэг илэрсэн тохиолдолд онлайнаар оролцсон аймгийн нийт оролцогчдын оноо 0 болгоно.
- 3.9. Хэрэв бүсийн олимпиадыг мэдээлэл зүйн олимпиадын хороо (ММЗБТН НҮТББ)-ы нэгдсэн системийг ашиглан явуулах бол тухайн системийг ашигласан болон үйлчилгээний хураамж төлөх ба төлбөрийн хэмжээг ангилал бүрээр мэдээлэл зүйн олимпиадын хороо тогтооно.
- 3.10. Олимпиадыг зохион байгуулж буй аймаг нь энэхүү удирдамжийг баримтлах ба мөн тусгай удирдамж гарган явуулж болно.
- 3.11. Бүсийн олимпиадад бүсэд харьяалагдаж буй аймгийн тооноос хамаарч аймаг бүрээс ангилал бүрд **3-5** оролцогчийг өмнөх давааны амжилтыг харгалзан оролцуулна. Бүсийн олимпиадын оролцогчийн тооноос үл хамааран нэг бүсээс улсын олимпиадад оролцох оролцогчийн тоо нь ангилал бүрд 2 байх ба улсын олимпиадад хувийн зардлаар оролцоно.

- 3.12. “Улсын мэдээлэл зүйн олимпиадыг зохион байгуулах удирдамж” – ийн 3.1.3-т заасны дагуу 2026 оны 3 дугаар сарын 06-аас 07-ны өдрүүдэд явуулна. Оролцогчид 30 минутын өмнө суудлаа эзэлсэн байна.
- 3.12.1. 2026.03.06-ы 12:00 цагаас Дунд ангилал
- 3.12.2. 2026.03.07-ы 09:00 цагаас Ахлах ангилал
- 3.12.3. 2026.03.07-ы 14:00 цагаас Багш ангилал тус тус явагдана.
- 3.13. Нийслэлийн болон бүсийн олимпиадын ангилал бүр нь 1 өдөр зохион байгуулагдах ба ангилал бүр 3 бодлогыг 4 цагийн хугацаанд бодож өрсөлдөнө.
- 3.14. Бодлого нь олон улсын олимпиадын түвшинд ойртсон, түүний жишгээр тавигдсан байх ба автомат шүүлтийн системээр үнэлэх боломжтой байна.
- 3.15. Ангилал бүрийн бодлогыг олимпиадын бодлого сонгох комисс сонгон автомат шүүлтийн системд байрлуулан шалгасан байна.
- 3.16. Бүсийн олимпиадыг зохион байгуулж буй аймаг нь олимпиадад ашиглах сервер зохион байгуулж, олон улсын автомат шүүлтийн системийг ашиглан дотоод сүлжээ ашиглан явуулах ба системийн найдвартай ажиллагаа, аюулгүй байдал болон техникийн аливаа асуудлыг бүсийн олимпиадыг зохион байгуулж буй аймаг хариуцна.
- 3.17. Олимпиадад оролцогчийн бодолтыг автомат шүүлтийн системээр хүний оролцоогүй шүүх ба бодлогыг C, C++ хэл дээр бодно.
- 3.18. Олимпиад явагдаж байх үед онооны самбарыг оролцогчдод харуулахгүй.
- 3.19. Бодлогын талаарх асуулт, тодруулах зүйлийг автомат шүүлтийн системийн “Questions” үйлчилгээгээр олимпиадын эхний 2 цагийн дотор авч болно.
- 3.20. Асуултын хариулт нь зөвхөн “Yes”, “No”, “Invalid question” “No comment”, “Answered in task description” гэсэн хариултаас өгнө.
- 3.21. Олимпиадын явцад нэн шаардлагатай тухайлбал, бодлогын өгүүлбэр, тесттэй холбоотой асуудал гарсан бол оролцогчдод нэмэлт тайлбар, мэдээллийг автомат шүүлтийн системийн “Announcements” үйлчилгээгээр өгнө.
- 3.22. Олимпиадад амжилттай оролцогчдын шагнал урамшууллыг зохион байгуулж байгаа аймаг хариуцна.

4. Бүртгэл

- 4.1. Зохион байгуулж байгаа аймгийн БШУГ-аас өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу зохион байгуулна.

5. Бодлогыг хүргэх ба бусад асуудал

- 5.1. Бүсийн олимпиадын бодлого нь нийслэлийн олимпиадын бодлоготой адилхан байна.
- 5.2. Нийслэлийн болон бүсийн олимпиадыг зохион байгуулах комисс нь техникийн зөвлөгөөнөөрөө зохион байгуулалтын асуудлаа хэлэлцэн шийдвэрлэж, бүх оролцогчдод практик дадлага хийж, компьютер, онлайн шүүлтийн систем болон программчлалын орчинтой танилцах боломжийг олгосон байна.
- 5.3. Олимпиадад оролцогч нь онлайн шүүлтийн системд бодлого тус бүрийг 30 удаа илгээн үнэлгээ хийлгэх эрх олгох бөгөөд хоёр дараалсан илгээлтийн хоорондох хугацаа 1 минут байхаар тохируулсан байна.
- 5.4. Мэдээлэл зүйн олимпиадын бодлогын оноог аравтын бутархайн 2 орны нарийвчлалтай үнэлэхээр тохируулсан байна.
- 5.5. Олимпиадын шагналт байр шалгарсан оролцогчийн оноо тэнцсэн тохиолдолд нийслэл, бүсийн олимпиад зохион байгуулах комисс хэлэлцэн шийдвэрлэх ба хэрхэн шийдвэрлэсэн талаарх протокол үйлдэж, оролцогч, бэлтгэсэн багш нарт танилцуулан шийдвэрийг зөвшөөрсөн талаар гарын үсэг зуруулсан байна.
- 5.6. Олимпиадад оролцогчдын оноо шагналт байрт тэнцсэн тохиолдолд дараах дүрмээр эрэмбэлнэ. Үүнд:
- 5.6.1. Бүтэн бодолт олон хийсэн оролцогчийг эхэнд нь эрэмбэлнэ.

Жишээ 1:

Оролцогч	Бодлого1	Бодлого2	Бодлого3	Нийт оноо	Эрэмбэ
Оролцогч1	100	70	30	200	2
Оролцогч2	100	100	0	200	1

5.6.2. 5.6.1 шалгуураар эрэмбэлэгдэхгүй бол тэрхүү эрэмбэлэх боломжгүй бодлогуудын хувьд хамгийн өндөр оноотой шийдэл гаргасан оролцогчийг эхэнд эрэмбэлнэ.

Жишээ 2: Оролцогч 2 бүтэн бодоогүй үлдсэн хоёр бодлогын хувьд хамгийн өндөр буюу 80 оноо авснаар эхэнд нь эрэмбэлэгдэж байна.

Оролцогч	Бодлого1	Бодлого2	Бодлого3	Нийт оноо	Эрэмбэ
Оролцогч1	100	70	30	200	2
Оролцогч2	100	20	80	200	1

Жишээ 3: Оролцогч1 гурван бодлогын хувьд хамгийн өндөр буюу 90 оноо авснаар эхэнд нь эрэмбэлнэ.

Оролцогч	Бодлого1	Бодлого2	Бодлого3	Нийт оноо	Эрэмбэ
Оролцогч1	60	90	50	200	1
Оролцогч2	70	70	60	200	2

5.6.3. Дээрх шалгууруудаар эрэмбэлэгдэх боломжгүй бол оноо тэнцсэн ижил бодлогуудын тэр оноог авсан сүүлийн бодолтыг сонгож, оноо авсан тест бүрд зарцуулсан хугацаа (Execution time)-ны нийлбэр багатай нь эхэнд эрэмбэлэгдэнэ. /Жич: CMS дээр ажиллах QUERY-г тухайн үед ажиллах зааврын хамт өгнө./

